



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/168


Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дах хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.9 дэх заалт, Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах комиссын 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр тэмдэглэл, 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 02 дугаар тэмдэглэл, 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 03 дугаар тэмдэглэл, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцсэн 4 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын
 2020 оны 02 сарын 12-ны өдрийн
 А. дугаар тушаалын хавсралт
 168

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТАД ТЭНЦСЭН
 ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
 ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сөри/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Жон Су Гён Jung Sookyoung	Бүгд Найрамдах Солонгос Улс	"Ач тус хоспис" ХХК-ний Агаар хоспис	-	ГЭ0002521	Эх барих, эмэгтэйчүүд судлал	Эмчлэх	1 жил
2.	Хан Ён Хунь Han Younghoon	Бүгд Найрамдах Солонгос Улс	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлэг	-	ГЭ0002522	Чих, хамар, хоолой судлал	Эмчлэх	1 жил
3.	Грундлинг Лузанне Хелен Gründling Luzanne Heleen	Бүгд Найрамдах Солонгос Улс	"Медика Монголиа" ХХК-ний эмнэлэг	-	ГЭ0002523	Яаралтай тусламж судлал	Эмчлэх	1 жил
4.	Кабрера Роче Освалдо Cabrera Roche Osvaldo	Бүгд Найрамдах Куба Улс	"Довлоо" ХХК-ний "Юнайтэд Дэнт" эмнэлэг	-	ГЭ0002524	Нүүр ам судлал	Эмчлэх	1 жил